

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 08 дугаар сарын 03-ны өдөр

№ 23/23

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын зорилгод нийцүүлэн, Компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээх зорилтын хүрээнд Компанийн ТУЗ-ийн 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 18/13 тоот тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасны дагуу нэмэлт, өөрчлөлт орж буй “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн ТУЗ-ийн нийт гишүүд, Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.
4. Энэхүү нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 08 дугаар сарын 03-ны өдөр

№ 23/24

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын зорилгод нийцүүлэн, Компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээх зорилтын хүрээнд Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй зохицуулалтуудыг нэгтгэж, бие даасан хэлбэр бүхий дор дурдсан журмуудыг баталсугай:
 - 1.1. энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам”;
 - 1.2. энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”;
 - 1.3. энэхүү тогтоолын 3 дугаар хавсралтаар “Залгамж халааны бодлого”;
 - 1.4. энэхүү тогтоолын 4 дүгээр хавсралтаар “Мэдээллийн ил тод байдлын тухай журам”.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан журмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн ТУЗ-ийн нийт гишүүд, Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.

